- (б) ГЕН-ийн 2.6.1-ийн (а)-гаас (в) хүртлэх, мөн (е) заалтын дагуу гэрээг цуцалснаас бусад тохиолдолд зөвлөхийн ажилтнууд,

тэдний хууль ёсны хамтран амьдрагч нарыг буцаах замын зардал зэрэг гэрээг цуцласны улмаас үүсэх аливаа бодит зардлын нөхөн олговор:

3. ЗӨВЛӨХИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1 Ерөнхий зүйл

3.1.1 Гүйцэтгэлийн чанар

Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материаллын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.

Зөвлөх нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.

3.2 Ашиг сонирхлын зөрчил

Зөвлөх нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстой бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхолын зөрчилд орохоос зайлсхийх ёстой.

3.3 Нууцлал

Зөвлөх, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсан аливаа нууц мэдээллийг ямар нэгэн хувь хүн, байгууллагад дамжуулах эрхгүй бөгөөд үйлчилгээний үр дүнд боловсруулсан зөвлөмжийг нийтэд нээлттэй болгох эрхгүй

3.4 Зөвлөхийн хариуцах даатгал

Зөвлөх нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзолын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.

3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа

Зөвлөх нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд:

(а) Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх,

(б) Хавсралт №1-т заасан ажилтны жагсаалтанд ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах.

(в) ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа

3.6 Тайлагнах хуваарь

Зөвлөх нь Хавсралт №2 -т заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хүргүүлэх ёстой.

3.7 Зөвлөхийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь

Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид хүргүүлнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно.

3.8 Нягтлан бодох бүртгэл, Хяналт шалгалт болон Аудит

Зөвлөх нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.

4. ЗӨВЛӨХИЙН АЖИЛТНУУД

- 4.1 Ажиллах хүчний тодорхойлолт** Зөвлөхийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Хавсралт №3-т тусгана. Захиалагчтай урьдчилан тохиролцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтанд багтаана.
- 4.2 Ажилтныг халах буюу солих**
- (а) Захиалагч зөвшөөрөөгүй бол ажиллах хүчний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Зөвлөхийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй тавина.
 - (б) Аль нэгэн ажилтан үүргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд захиалагчаас бичгээр гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстой.
 - (в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсч болох ямар нэгэн нэмэлт зардлыг зөвлөх нэхэмжлэх эрхгүй болно.

5. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 5.1 Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох** Захиалагч нь ГТН-д заасан зөвлөхөд үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг засгийн газрын зүгээс олгуулахын тулд бүх талын хүчин чармайлт гаргана.
- 5.2 Гэрээнд хэрэглэх хуулинд татвар хураамжийн талаар орсон өөрчлөлт** Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуулинд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Зөвлөхийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиролцон гэрээний дагуу Зөвлөхөд төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б), -д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстой.
- 5.3 Захиалагчийн зүгээс үзүүлэх үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгө** Захиалагч нь үйлчилгээний зорилгоор ашиглуулахаар Хавсралт 3.3-д заасан үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг тогтоосон хугацаанд үнэ төлбөргүйгээр Зөвлөхөд гарган өгөх ёстой.

6. ЗӨВЛӨХӨД ТӨЛӨХ ТӨЛБӨР

- 6.1 Нийт төлбөр** Зөвлөхөд төлөх нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний хавсралт №1-т тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчлөснөөс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцхүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно.
- 6.2 Гэрээний үнэ**
- (а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
 - (б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.

- 6.3 Нэмэлт үйлчилгээний төлбөр** ГЕН-ийн 2.4-т заасны дагуу төлөхөөр зөвшөөрч болох нэмэлт үйлчилгээний цалингийн хэмжээг тодорхойлохын тулд нийт үнийн задаргааг Хавсралт №4 болон №5-д оруулна.
- 6.4 Төлбөр хийх нөхцөл. хуваарь** Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан зөвлөхийн дансанд хийнэ. ГТН-д өөрөөр заагаагүй бол, түүнд тогтоосон хугацаанд хүчинтэй байхаар тооцож, зөвлөхийн ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнтэй тэнцэх хэмжээгээр эхний төлбөрийг хийнэ. Энэхүү баталгааг Хавсралт №7-д заасан маягт, эсхүл захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрсөн өөр маягтаар гарган ирүүлнэ.
- ГТН-д заасан нөхцөл болзолыг хангасны дараа, зөвлөхөд төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстой.
- 6.5 Хугацаа хоцорсон төлбөрийн хүү** Захиалагч нь ГТН-ийн 6.4-д тогтоосон төлбөр хийх хугацааг арван таван хоногоос (15) дээш хоногоор хэтрүүлсэн бол хугацаа хоцорсон хоног тутам ГТН-д тогтоосон хэмжээгээр зөвлөхөд хүү төлөх ёстой.

7. ШУДАРГА БАЙДАЛ

- 7.1 Шударга байдал** Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биенийхээ эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгыг хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.

8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх** Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтанд ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 8.2 Маргааныг шийдвэрлэх** Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй.

III. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

(Хаалтанд байгаа зүйлийг { } сонгон хэрэглэнэ; эцэслэн боловсруулалт хийхэд тэмдэглэлийг хасна)

ГЕН-ийн зүйлийн дугаар	Гэрээний ерөнхий нөхцлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчлөнө.
{1.1(a)}	Гэрээнд хэрэглэх хууль нь Харилцаа холбооны тухай, Их хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хуулиуд байна.
1.3	Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.
1.4	Захиалагчийн хаяг: Харилцаа холбооны зохицуулах хороо Метро бизнес төв А-блок 5 давхар Д.Сүхбаатарын гудамж-13 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201-0033 Захиалагч: Харилцаа холбооны зохицуулах хороо Харилцах хүн: Н.Тогтохсүрэн ЗБХГ-ын МАЧСЗМХ-ийн дарга Утас: +976-11-304258 Факс: +976-11-327720 Захиалагч: Харилцах хүн: Утас: Факс: И-мэйл:
1.7	Итгэмжлэгдсэн төлөөлөгчид: Захиалагчийн: Н.Тогтохсүрэн ЗБХГ-ын МАЧСЗМХ-ийн дарга болон УБ хотын өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Зөвлөхийн:
1.8	Татвар: Зөвлөхийн ажиллах хүчин нь хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлнө. <hr/> Тэмдэглэл: Гэрээнд хэрэглэх хуулийн дагуу зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажилтнуудын төлбөл зохих татвар хураамж болон эсхүл захиалагч нөхөн олгох буюу эсхүл тодорхой татвар, хураамж төлбөрөөс чөлөөлөгдөх ёстой зэргийг энд оруулна.
2.2	Тогтоосон хугацаа: Зөвлөх нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш аль болох богино хугацаанд буюу 2020 оны 05 дугаар сарын 01-ний дотор үйлчилгээг эхлэх ёстой бөгөөд заасан хугацаанаас өмнө үйлчилгээг эхлэхийг эрмэлзэнэ.
2.3	Тогтоосон хугацаа: Гэрээ хүчин төгөлдөр болж, үйлчилгээ эхэлснээс хойш 12 сарын хугацаанд хөтөлбөрийн хяналт, мониторингийн ажлыг хийж гүйцэтгэж дуусган Захиалагч талд эцсийн тайлан (12 дахь сарын тайлан)-г хүлээлгэн өгсөнөөр гэрээний хугацаа дуусгавар болно.

2.4	Захиалагчийн зүгээс тухайн цаг үеийн нэмэлтээр үйлчилгээний цар хүрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт үйлчилгээ нь зөвхөн тухайн тодорхой цаг хугацааг хамарна.
{3.5 (в)}	<p>Гүйцэтгэгч нь дараах тохиолдолд захиалагчаас зөвшөөрөл авна:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Захиалагчтай байгуулсан гэрээт ажлын хүрээнд хийгдсэн мониторинг, мониторингийн дүн, тайлан, мэдээ, аналитик судалгаа болон холбогдох бусад тайланг нийтлэх, нэвтрүүлэх, түгээх, борлуулах; ▪ Зөвлөхийн албан ёсны хаяг, байршил өөрчлөгдөх; ▪ Тендерийн саналд ирүүлсэн зөвлөхийн техникийн нөхцөл, боломж, чадавхи өөрчлөгдөх; ▪ Бусад. <p>Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гишүүн, итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, эрх барих этгээд, гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт оруулах тохиолдолд захиалагчид урьдчилан мэдэгдсэн байна.</p>
6.2(б)	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: <i>[хэмжээг тоо болон үсгээр оруул]</i>
6.4	<p>Төлбөр хийх данснууд: Төгрөгийн хувьд: <i>[дансны нэр, дугаарыг оруул].</i></p> <p>Төлбөрийг дараахь хуваарийн дагуу төлнө. Төлбөрийг сар бүрийн гүйцэтгэлд үндэслэж төлнө.</p> <p>(а) Байнгын мониторингийн сар бүрийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэлийн тайланг хүлээн авч, гүйцэтгэлийг хүлээн зөвшөөрсний дараа гэрээний тухайн сард ноогдох үнийн дүнг төлнө.</p> <p>(б) Сонгуулийн сурталчилгааны мониторингийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэлийн тайланг хүлээн авч, гүйцэтгэлийг хүлээн зөвшөөрсний дараа тухайн үйлчилгээнд ноогдох үнийн дүнг төлнө.</p> <p>(в) Урьдчилгаа төлбөр олгохгүй.</p>
6.5	Хүүгийн хувь хэмжээ: <i>0,1</i>
8.2	Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

IV. ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ №1 – ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Тэмдэглэл: Энэхүү хавсралт нь техникийн хэлэлцээрийн явцад захиалагч болон зөвлөхийн эцэслэн тохиролцсон ажлын даалгавар, тодорхой ажлуудыг дуусгавар болгох огноо, зарим ажлуудыг гүйцэтгэх байршил, захиалагчийн зөвшөөрлийг авбал зохих тодорхой ажлуудын талаарх мэдээллийг агуулна.

ХАВСРАЛТ №2 - ТАЙЛАН ГАРГАХ ХУВААРЬ

Тэмдэглэл: Тайлангийн агуулга болон түүнийг гарган ирүүлэх маягт, давтамж: хүлээн авах хүн: ирүүлэх огнооны талаарх мэдээллийн жагсаалт.

ХАВСРАЛТ №3 - ГОЛЛОХ МЭРГЭЖИЛТЭН БОЛОН ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ

Тэмдэглэл: Дараах зүйлсийг багтаана:

- C-1 Үйлчилгээ үзүүлэх гадаадын голлох мэргэжилтний ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолт, шаардлагатай чадварын түвшин, Албан тушаал [боломжтой бол овог, нэрээр], болон голлох мэргэжилтэн бүрээр хүн-сараар ажиллах хугацааг оруул.*
- C-2 Үйлчилгээтэй холбоотой ажлыг гадаадад гүйцэтгэх голлох мэргэжилтний ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолт, шаардлагатай чадварын түвшин, Албан тушаал [боломжтой бол овог, нэрээр], болон голлох мэргэжилтэн бүрээр хүн-сараар ажиллах хугацааг оруул.*
- C-3 Зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчийн жагсаалт: тэдгээрийн голлох ажилтантай холбоо бүхий дээрх хавсралт бүртэй ижил мэдээлэл*
- C-4 Дотоодын голлох мэргэжилтний талаарх дээрхийн ижил мэдээлэл.*

ХАВСРАЛТ №4 - ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ЗАДАРГАА (ГАДААД МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР)

Тэмдэглэл: Гадаад мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэх нийт-үнэ өртгийн задаргаанд буй үнийн бүтцийн жагсаалтыг оруул:

- 1. Ажилтны сарын цалингийн хэмжээ (Голлох мэргэжилтэн болон бусад ажилтан)*
- 2. Нөхөн төлөгдөх зардал.*

Энэхүү хавсралтыг зөвхөн нэмэлт үйлчилгээний төлбөрийг тодорхойлохын тулд ашиглана.

ХАВСРАЛТ №5 - ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ЗАДАРГАА (ТӨГРӨГӨӨР)

Тэмдэглэл: Төгрөгөөр илэрхийлэгдэх нийт-үнэ өртгийн задаргаанд буй үнийн бүтцийн жагсаалтыг оруул:

- 1. Ажилтны сарын цалингийн хэмжээ (Голлох мэргэжилтэн болон бусад ажилтан)*
- 2. Нөхөн төлөгдөх зардал.*

Энэхүү хавсралтыг зөвхөн нэмэлт үйлчилгээний төлбөрийг тодорхойлохын тулд ашиглана.

ХАВСРАЛТ №6 - ЗАХИАЛАГЧИЙН ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Тэмдэглэл: Дараах зүйлсийг багтаана:

№-1 *Захиалагчийн зүгээс зөвлөхөд үзүүлэх үйлчилгээ, байгууламж болон эд хөрөнгө.*

ХАВСРАЛТ №7 - УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]

[Зөвлөхийн нэр] (цаашид “зөвлөх” гэх) оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот *[Гэрээний нэр ба зөвлөх үйлчилгээний товч тодорхойлолт]* гэрээ (цаашид “гэрээ” гэх)-ний ерөнхий нөхцөлийн 6.4 заалтын дагуу хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхээ баталж *[Захиалагчийн нэр]*-ийн өмнө хариуцлага хүлээж *[Баталгааны мөнгөн дүн]* *[үсгээр]*¹⁵-ийн банкны баталгаа ирүүлэхтэй ХОЛБОГДУУЛАН,

[Банк нэр] (цаашид “Банк” гэх) нь зөвлөхийн нэрийн өмнөөс *[баталгааны дүн тоогоор, валют]* *[дүн үсгээр, валют]*¹⁶-ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, зөвлөх гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Захиалагч, зөвлөхийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, түүний дагуу үзүүлэх зөвлөх үйлчилгээ, гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь гэрээний нөхцөлийн дагуу зөвлөхөд урьдчилгаа төлбөр хийгдсэн өдрөөс захиалагчид дээр дурдсан дүнтэй ижил төлбөр эргэн төлөгдтөл хүчин төгөлдөр байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

¹⁵ Энэ дүнг банк, эсхүл санхүүгийн байгууллага бөглөх бөгөөд урьдчилгаа төлбөрийн үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь урьдчилгаа төлбөрийн валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

¹⁶ Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]

[Гүйцэтгэгчийн нэр] нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар гэрээний дагуу **[Гэрээний нэр ба зөвлөх үйлчилгээний товч тодорхойлолт]** (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

[Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс **[баталгааны дүн тоогоор, валют]** **[дүн үсгээр, валют]**¹⁷ –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан **[баталгааны дүн тоогоор, валют]** **[дүн үсгээр, валют]**-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

¹⁷ Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
Зохицуулалтын Бодлогыг Хэрэгжүүлэх Газар

“ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХӨТӨЛБӨРТ
БАЙНГЫН МОНИТОРИНГ ХИЙХ”
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

ХХЗХ/202001021

2020 он

АГУУЛГА

1. Үндэслэл
2. Зорилго
3. Хяналт, мониторингийн хамрах хүрээ
4. Хяналт, мониторинг хийх үзүүлэлт
5. Хяналт, мониторинг хийхэд баримтлах зарчим
6. Тайлан
7. Ажлын даалгаврын шалгуур шаардлага
8. Хэрэгжүүлэх арга зүй ба ажлын хуваарь
9. Тайлан ирүүлэх удирдамж

1. ҮНДЭСЛЭЛ

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хөгжлийг дэмжих, өргөн нэвтрүүлгийн талаар төрөөс баримталж байгаа бодлогын хүрээнд хүүхэд болон үзэгчийн эрх хамгаалах, нийтийн ашиг сонирхолд нийцсэн, чанартай үйлчилгээгээр олон нийтийг хүртээмжтэй хангах, зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор телевиз, сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөр, түгээр дамжуулах зар сурталчилгаа, олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн үйлчилгээний багц, гадаад дотоод сувгийн тоо төрөл, хуваарилалт болон бусад холбогдох шалгуур шаардлагыг тавьж хэрэгжилтэд байнгын хяналт, мониторинг хийж ажилладаг. Тус хороо нь “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ыг 2011 оны 07 тоот тогтоолоор (“Телевиз, радиогийн зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага”) анх баталж, 2015 оны 15 тоот тогтоолоор шинэчлэн найруулж, 2016 оны 29-р тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд тус хорооны зүгээс нөхцөл шаардлагын хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор телевиз, сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт хийх хяналт мониторингийг тасралтгүй, тогтвортой хийх, зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байдаг.

Зохицуулах хороо нь Монгол Улсын Сонгуулийн тухай хуулиар олгосон эрх үүргийн дагуу “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангуулж ажилладаг бөгөөд энэ хүрээнд 2012, 2016 оны УИХ-ын сонгууль, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр радио, телевизээр дамжуулсан сонгуулийн сурталчилгаанд хяналт мониторинг хийж хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан. Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуульд нийцүүлэн гаргасан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор тус хорооноос тусгай зөвшөөрөлтэй телевиз, сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрөөр дамжуулах сонгуулийн сурталчилгаанд хяналт, мониторинг хийх, холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

2. ЗОРИЛГО

Энэхүү ажлын даалгаврын гол зорилго нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль болон тус хорооноос олгож байгаа өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн гэрээ, нөхцөл шаардлагын хүрээнд хөтөлбөрт тавигдах нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хяналт, мониторинг хийх (цаашид “хяналт, мониторинг хийх” гэх), нөхцөл шаардлага хангаж ажилласан эсэх дүнг сар бүр нэгтгэн гаргах, нээлттэй байршуулах, сар бүр, улирал, жилийн нэгдсэн дүнгээр холбогдох харьцуулалтыг хийх, судалгаа гаргах, нөхцөл шаардлага хангаагүй үзүүлэлтийг ил тод байршуулах, зөрчлийг арилгуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахад оршино. Түүнчлэн хөтөлбөрт байнгын хяналт мониторинг хийснээр телевиз, сувгийн зах зээлийн мэдээлэл, зар сурталчилгааны зах зээлийн судалгаа, статистик тоон мэдээлэл бүрдэх, зохицуулалтын өнөөгийн байдалд үнэлэлт өгөх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох судалгааны суурь бий болохоос гадна илэрсэн зөрчил дутагдал, нөхцөл шаардлагад

заасан чиглэлээр гомдол маргаан үүссэн тохиолдолд ашиглах эфирийн бичлэг, тайлан протоколын архив, сан үүсэх боломжтой байдаг.

3. ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

- 3.1 Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”, “Монгол улсын нутаг дэвсгэрт телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг хүргэхэд тавигдах нөхцөл шаардлага”-ын дагуу Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа 20 өргөн нэвтрүүлгийн телевиз (МҮОНТВ-ийн телевиз орсон), Монгол Улсад хамрах хүрээтэй үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн 5 телевиз (хяналт, мониторингийн хугацаанд Ддэш ХХК-ийн олон сувгийн үйлчилгээнд холбогдон хөтөлбөрөө МУ-ын нутаг дэвсгэрт дамжуулж байгаа орон нутгийн телевиз, сувгийг тухай бүр нэмж оруулна), Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй 62 кабелийн суваг, үйл ажиллагаа явуулж байгаа 58+ кабелийн сувгийн (хяналт, мониторингийн хугацаанд тухайн ОСДҮЭ-ийн сүлжээнд холбогдож хөтөлбөр дамжуулж эхэлсэн сувгийг тухай бүр нэмнэ) хөтөлбөрт хяналт, мониторинг хийнэ.
- 3.2 Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хууль болон “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу тус хорооноос тусгай зөвшөөрөлтэй Улаанбаатар хот болон орон нутагт тусгай зөвшөөрөлтэй нийт 151 телевиз, сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийнэ.
- 3.3 Сувгуудын хувьд төрөлжсөн чиглэл, үндэсний бүтээлийн шаардлага хангасан, зар сурталчилгааны хэтрэлтгүй зэрэг нөхцөл шаардлагын хэрэгжилт, шаардлага хангасан байдлыг харгалзан Зохицуулах хорооноос шаардлагатай гэж үзвэл зарим сувгуудыг хяналт, мониторингийн үндсэн үзүүлэлтийн байнгын хяналтаас хасах, давтамжтайгаар түүвэрлэн хяналт, мониторинг хийх боломжтой байна.
- 3.4 Хяналт, мониторингийг өглөөний 06.00 цагаас шөнийн 01:00 цаг хүртэлх эфирийн цагаар хийнэ. Шаардлагатай нөхцөлд хяналт, мониторингийн цагийг 1-2 цагаас илүүгүйгээр сунгаж болно.
- 3.5 Сувгуудын хувьд өглөөний 06:00-01:00 цаг хүртэлх эфирийн цагийг хамруулна. Захиалагчийн зүгээс хяналт, мониторингид хамрагдах ТВ, сувгуудын жагсаалт, шаардагдах мэдээлийг шалгарсан оролцогчид гаргаж өгнө.
- 3.6 Захиалагч нь гүйцэтгэгчээс гэрээт ажлын хугацаанд өөрийн хуулиар хүлээсэн чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа гомдол, маргааныг шийдвэрлэх үүднээс тухайн маргаантай холбоотой телевиз, сувгуудын хөтөлбөрийн бичлэг авах, холбогдох мэдээллийг гаргуулж авах эрхтэй.
- 3.7 Захиалагч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын даалгаварт заасан хяналтын үзүүлэлтээр гарсан тайланг хамтын ажиллагаатай холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлж болно.

4. ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХ ҮЗҮҮЛЭЛТ

- 4.1 Хяналт, мониторингд хамаарах хөтөлбөрийн бүтцийг гадаад болон дотоод контент гэсэн үзүүлэлтээр хувааж, 7 хоногийн хөтөлбөрт гадаад болон дотоодын нэвтрүүлгийн эзлэж буй хувийг тодорхойлох, үүнээс дотоод нэвтрүүлэг нь нөхцөл шаардлагад заасан



- Үндэсний бүтээлийн /7 хоногийн нийт хөтөлбөрийн 50 хувиас доошгүй байх/ шаардлагыг хангасан эсэх;
- 4.2 Телевиз, сувгийн хөтөлбөрт гадаадын нэвтрүүлгийн эзлэж буй хугацааг тогтоох, гадаад нэвтрүүлгийг бүтээсэн улс орноор, нэвтрүүлгийн төрлөөр, жанраар тус тус ангилах, тухайн сарын шинэ дугаар, давталтын тоог гаргах; Телевиз, сувгийн хөтөлбөрт дотоод нэвтрүүлгийн эзлэж буй хугацааг тогтоох, дотоод нэвтрүүлгийг нэвтрүүлгийн төрлөөр, жанраар тус тус ангилах, тухайн сарын шинэ дугаар, давталтын тоог гаргах;
 - 4.3 Телевиз, сувгийн өөрийн бүтээлийн эзлэх хувь хэмжээг тодорхойлох, тухайн сарын шинэ дугаар, давталтын тоог гаргах;
 - 4.4 Хамрах хүрээ өргөжүүлсэн, хиймэл дагуулын сүлжээгээр хөтөлбөр дамжуулж байгаа орон нутгийн телевиз, сувгийн хөтөлбөрт эзлэх тухайн орон нутгийн бүтээлийн хугацаа, эзлэх хувь, хэмжээг тодорхойлох, нэвтрүүлгийн төрөл, жанраар тус тус ангилах, тухайн сарын шинэ дугаар, давталтын тоог гаргах;
 - 4.5 Телевиз, сувгаар нэвтрүүлж буй уран сайхны кино, олон ангит кино, хүүхдийн кино, хүүхэддэйн киног бүтээсэн улс орон, төрөл, жанраар ангилан гаргах, киноны насны ангилал, тэмдэг тэмдэглэлээний үзүүлэлтийг тайланд тусгах;
 - 4.6 Телевиз, сувгуудын нэвтрүүлж буй зар сурталчилгааны хугацааг тогтоох, үүнд: “1 цагт дамжуулах зар сурталчилгаа 15 минутаас хэтрэхгүй байх” нөхцөл шаардлага хангасан байдал;
 - 4.7 Нийт оргил цаг /18:00-23:59/ болон оргил цагийн нэг цаг тутамж нэвтрүүлж буй зар сурталчилгааны тайлан, зар сурталчилгааны хэтрэлтийн тайлан;
 - 4.8 Телевиз, сувгийн 1 цагт нэвтрүүлж буй зар сурталчилгаанд эзлэх блок, блок тус бүрт ноогдох хугацааг тогтоох;
 - 4.9 Телевиз, сувгуудын нэвтрүүлж буй зар сурталчилгаанд эзлэх нийгмийн шинжтэй зар сурталчилгааны хугацааг тогтоох;
 - 4.10 Телевиз, сувгийн хоногийн эфирийн нийт цаг болон 1 цагт нэвтрүүлж буй зар сурталчилгааны хугацааг тогтоох, зар сурталчилгааг нийлүүлэгч, үйл ажиллагааны чиглэл/салбар/-ээр нь ангилан гаргах;
 - 4.11 Телевиз, сувгаар нэвтрүүлж буй зар сурталчилгааг дотоод болон гадаад бүтээлээр ангилах, дотоод, гадаад сурталчилгааны бүтээлийн эзлэх хугацааг тухайн сараар тогтоох;
 - 4.12 Төлбөртэй сувгийн зөвшөөрөлтэй сувгаар зар сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх; Төлбөртэй сувгийн жагсаалтыг захиалагчаас гаргаж өгнө.
 - 4.13 Кабелийн сувгийн төрөлжсөн чиглэлийн хувь хэмжээ нь нэг өдрийн хөтөлбөрийн (06:00-24:00) нийт цагийн 80%-д, танин мэдэхүйн чиглэлээр төрөлжсөн сувгийн нэг өдрийн хөтөлбөрийн (06:00-24:00) нийт цагийн 60%-д, танин мэдэхүйн төрөлжсөн сувгийн 18:00-23:00 цагийн хоорондох нийт эфирийн цагийн 80%-д зөвхөн төрөлжсөн чиглэлээр бэлтгэсэн нэвтрүүлэг байх шаардлагын хэрэгжилт, төрөлжсөн нэвтрүүлгийн хувь хэмжээ, тайлан;
 - 4.14 Төрөлжсөн чиглэлд тооцогдох нэвтрүүлгийг бүтээсэн улс орноор, нэвтрүүлгийн төрөл, жанраар ангилан гаргах;
 - 4.15 Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх, хүүхэд боловсролын нэвтрүүлгийн 1 сарын хөтөлбөрт эзлэх нийт хувь хэмжээг тодорхойлох, энэ хувь нь 1 сарын хөтөлбөрийн нийт цагийн 15%-иас багагүй байх, МУ-ын нутаг дэвсгэрт

- 20%-иас багагүй байх шаардлага хангасан эсэх, нэвтрүүлгийг бүтээсэн улс орноор, тухайн сард гарсан шинэ дугаар, давталтын тоог гаргах;
(Соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх, хүүхэд боловсролын чиглэлийн нэвтрүүлэгт дараах төрлийн нэвтрүүлгийг ойлгоно. Үүнд хүүхэд хүмүүжил боловсролын нэвтрүүлэг; үндэсний хэл соёл, зан заншил, түүх, уламжлалын нэвтрүүлэг; эрүүл мэнд байгаль экологийн нэвтрүүлэг; шинжлэх ухаан танин мэдэхүйн нэвтрүүлэг.)
- 4.16 Телевиз, кабелийн сувгаар дамжуулж байгаа хүүхдийн нэвтрүүлгийн нийт цаг, нэвтрүүлгийн тоо, давталтын дугаар болон шинэ дугаарын цаг, хувь хэмжээ. Хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн төрөл, жанраар ангилах, бүтээсэн улс орноор ангилах, хөтөлбөрт эзлэх цагаар гаргах. Хүүхэд боловсрол, танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэл, бичгэн тайлбартай гарсан эсэх, нэвтрүүлгийн тоо;
- 4.17 Зар сурталчилгааны цагаас бусад цагт нэвтрүүлж буй нэвтрүүлгийн үеэр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний баннер хэлбэрийн зар сурталчилгаа, логог дэлгэц дээр гаргаж байгаа эсэх; /тухайн телевиз, сувгийн өөрийн хөтөлбөрийн талаарх мэдээлэл /нэкст/-ийг баннер хэлбэрийн зар сурталчилгаанд оруулж тооцохгүй/
- 4.18 Насанд хүрэгчдэд зориулсан насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээтэй буюу 18 наснаас дээш насныханд зориулсан кино, нэвтрүүлгийг өглөө 06:00-22:00-ийн хооронд нэвтрүүлэх, давтан дамжуулж байгаа эсэх;
- 4.19 Зохисгүй агуулга, контент бүхий дүрс бичлэг, кино, нэвтрүүлэг, хөтөлбөрийг бүртгэлжүүлэх, тодорхой үзүүлэлтээр тайлан, мэдээ гаргах; /Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт хүүхэд хамгаалах чиглэлээр баримтлах зөвлөмж, хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм-ийг удирдамж болгоно/
- 4.20 Теле-худалдааны чиглэлээр төрөлжсөн сувгуудын 7 хоногийн хөтөлбөрт эзлэх, бараа бүтээгдэхүүний сурталчилгааны нийт цагийн 10%-иас доошгүй нь үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний сурталчилгаа байгаа эсэх,
- 4.21 Теле-худалдааны суваг нь өөрийн теле-худалдааны сувгаар дамжуулан борлуулдаг бараа бүтээгдэхүүнээс бусад бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилсан, бизнес мэдээ зэрэг арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг дамжуулсан бол хөтөлбөрийн нийт цагт эзлэх хувь, хөтөлбөрийн нийт цагийн 15%-иас хэтэрсэн эсэх;
- 4.22 Теле-худалдааны суваг нь зар сурталчилгаа (реклам) нэвтрүүлсэн эсэх;
- 4.23 ОСДҮЭ-ийн гадаад сувгийн жагсаалт, гадаад сувгийн эрхийг эзэмшигч улсын нэр, дамжуулагдаж байгаа хэл, сувгийн хөтөлбөрийн төрөл жанр, чиглэл /өргөн нэвтрүүлгийн телевиз, төрөлжсөн суваг, тухайн улс үндэстний соёл, уламжлалыг бусад улсад сурталчлах зорилго бүхий англи хэл дээрх суваг/, гадаад сувгийн хөтөлбөрөөр зар сурталчилгаа дамжуулдаг эсэх талаарх мэдээлэл; ОСДҮЭ-ийн үндсэн багцад хамаарах дотоодын сувгийн мэдээлэл, жагсаалт;
- 4.24 Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуульд нийцүүлэн гаргасан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд хуульд заасан сонгуулийн сурталчилгааны хугацаанд дараах үзүүлэлтийн дагуу хяналт, мониторинг хийнэ. Үүнд:
- Радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт 60 минутаас илүүгүй заалтыг хангасан байдал;

- Сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдож байгаа эсэх, шаардлага хангасан эсэх;
- Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамаарахгүй боловч нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт таван минутаас хэтрүүлэхийг хориглох заалтын хэрэгжилтийн байдал;
- Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсоосон эсэх, зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх;
- Сонгуулийн сурталчилгаа зогсоох хугацаанаас өмнөх 48 цагт хуулиар тогтоосон 60 минут, 15 минутаас илүүгүй байх хугацааг зөрчсөн эсэх болон сонгуулийн сурталчилгааны хугацаанд нам, эвслийн дарга, нэр дэвшигчийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орсоньг дамжуулсан, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлсэн эсэх;
- Дахин болон нэмэлт санал хураалт дуусталх хугацаанд сонгуулийн сурталчилгаа дамжуулсан эсэх;
- Сонгуулийн сурталчилгааны эх сурвалжийг ил тод мэдээлсэн байдал. Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын доод хэсэгт сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих бөгөөд энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна. Радиогийн нэвтрүүлгийн тухайд эхлэл, төгсгөлд нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдана.
- Улс төрийн мэтгэлцээний талаарх нэвтрүүлгийн хяналт, оролцогчдын төлөөлөл шаардлага хангасан байдал. Улс төрийн мэтгэлцээний талаарх нэвтрүүлэг, хөтөлбөр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамаарахгүй боловч уг нэвтрүүлэг, хөтөлбөрт нэг намын бус, түүнчлэн бие даагч хэд хэдэн нэр дэвшигч, эсхүл өөр өөр нам, эвслийн дөрвөөс доошгүй төлөөлөл оролцсон байна.
- Улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан эсэх, хэрэгжилтийн байдал;
- Нам, эвслийн дарга, түүнчлэн нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орохыг, түүнчлэн сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлсэн эсэх, хэрэгжилтийн байдал;
- Эрх бүхий байгууллагаас сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх олгосоноос бусад радио, телевизээр сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн эсэх, хэрэгжилт;
- Радио, телевиз нь нэгээс илүү сувагтай бол сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн үндсэн сувгаар нэвтрүүлсэн эсэх;



- Радио, телевизийн редакцид бэлтгэгдээгүй, сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн зүгээс бэлтгэн нийлүүлсэн мэдээ, нэвтрүүлгийг тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамааруулна.
 - Олон нийтийн радио, телевизээр дамжуулах сонгуулийн сурталчилгааны батлагдсан хуваарь, цагийн биелэлтэд мониторинг хийх, хэрэгжилтэд хяналт тавих;
 - Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу дахин болон нэмэлт санал хураалт явуулах тохиолдолд дахин болон нэмэлт санал хураалт явуулж, сонгуулийн албан ёсны дүн зарлагдаж дуусах хугацаанд сонгуулийн сурталчилгаа дамжуулж байгаа эсэхэд хяналт, мониторинг хийх.
 - Хууль, журамд заасан бусад үзүүлэлт.
- 4.25 Хяналт, мониторингоор телевиз, суваг нь сувгийн нэр, үйлчилгээний нэрийг өөрчилсөн тохиолдолд энэ талаар Захиалагч байгууллагад шуурхай мэдэгдэж тодруулга авна. Долоо хоногт 1 удаа хайлт хийж жагсаалтад шинээр нэмэгдсэн болон хасагдсан телевиз, сувгийн талаарх мэдээллийг Захиалагч байгууллагад шуурхай гаргаж өгнө.
- 4.26 Захиалагчаас шаардсаны дагуу холбогдох эфирийн дүрс, бичлэг, хөтөлбөрийн баримт, нотолгоог шуурхай гаргаж ирүүлнэ.
- 4.27 Мэдээллийн сангаас шаардлагатай тохиолдолд холбогдох үзүүлэлтээр нэмэлт мэдээ, тайланг боловсруулалт хийн түргэн шуурхай гаргах боломжтой байх.

5. ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Хяналт, мониторинг хийх үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо ХХЗХ-ны 2015 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ын 7 дугаар зүйлд заасан өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, сувгийн хөтөлбөрт тавигдах шаардлагыг баримтална. Тухайлбал:

- 5.1 Дотоод буюу үндэсний нэвтрүүлгийн хувь хэмжээг тооцоход:
- 5.1.1 Долоо хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 50 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна. (7.4)
- 5.1.2 Үндэсний нэвтрүүлгийн хувийг тооцохдоо дараах нэвтрүүлгийг нэмж тооцно.
- Монгол үндэстний эрх ашиг, соёл, эх хэл, зан заншил, ахуй амьдралыг сурталчилсан, таниулсанмонгол хэл дээр орчуулсан гадаадын мэдээ,мэдээллийн хөтөлбөр, ярилцлага,нэвтрүүлэг, баримтат кино;
 - Тив, дэлхийн хэмжээний урлаг,спортын арга хэмжээг албан ёсны эрхтэйгээр монгол хэл дээр, хөтөлгч тайлбарлагчтайгаар дамжуулж байгаа нэвтрүүлэг;
 - Нэвтрүүлгийн давталт.
- 5.1.3 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 7.4-т заасан хувийг тооцохдоо монгол хэл дээр орчуулсан гадаадын нэвтрүүлэг, уран сайхны болон баримтат кино, гадаадын хүүхэлдэйн киног тооцохгүй. (7.5)
- 5.1.4 Үндэсний бүтээл болон өөрийн бүтээлийн хувийг тооцоход үгэн зарын цаг, бизнес мэдээ болон бусад хэлбэрээр явуулж байгаа арилжаа сурталчилгааны нэвтрүүлгийг оруулж тооцохгүй. (7.6)

- 5.1.5 Үндэсний бүтээл болон өөрийн бүтээлийн хувийг тооцоход үгэн зарын цаг, бизнес мэдээ болон бусад хэлбэрээр явуулж байгаа арилжаа сурталчилгааны нэвтрүүлгийг оруулж тооцохгүй. (7.7)
- 5.2 Зар сурталчилгааны хугацааг тооцоход:
- 5.2.1 Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь зар сурталчилгааны эхлэл болон төгсгөлийг үзэгчдэд дуу, дүрсээр ойлгомжтой байдлаар илэрхийлнэ. (7.27)
- 5.2.2 Өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн нэг цаг тутамд дамжуулах зар сурталчилгаа (реклам) нь 15 (арван таван) минутаас хэтрэхгүй байна.(7.28)
- 5.2.3 Тухайн цагт дамжуулах зар сурталчилгааны 15 минутыг дараагийн цагт хамаарах зар сурталчилгаатай нэгтгэж, үргэлжлүүлэн явуулахгүй.(7.29)
- 5.2.4 Нийгмийн шинжтэй зар сурталчилгаа, телевизийн өөрийн болон хөтөлбөрөө сурталчилсан сурталчилгааг зар сурталчилгааны хязгаарлалтад оруулж тооцохгүй (7.31)
- 5.2.5 Энэхүү нөхцөл шаардлагын 3.1.11-д тодорхойлсон арилжаа, сурталчилгааны нэвтрүүлгийг зар сурталчилгааны хязгаарлалтанд оруулж тооцохгүй.(7.32)
- 5.2.6 Бизнес эрхлэгчид, иргэд, олон нийтийн байгууллагын мэдээлэл, сурталчилгааг зар сурталчилгааны (реклам) хэлбэрээр бус, фото, баннер, үгэн болон урсдаг зарын хэлбэрээр урьдчилан боловсруулж, хөтөлбөр хуваарьт оруулан, тусгайлан гаргасан зарын цагаар монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу алдаагүй, дуу оруулгатай нэвтрүүлж болно. (7.37)
- 5.2.7 Энэхүү нөхцөл шаардлагын 7.37-д заасан хэлбэрээр нэвтрүүлсэн зарыг 1 цагт дамжуулах зар сурталчилгааны хязгаарлалтад оруулж тооцно (7.39)
- 5.2.8 Теле-худалдааны чиглэлээр төрөлжсөн телевизийн сувгаас бусад өргөн нэвтрүүлгийн телевиз, телевизийн сувгаар бараа бүтээгдэхүүнийг студид байрлуулж сурталчлан борлуулсан тв тохиролцоо, тв худалдааны төрлийн нэвтрүүлэг дамжуулахгүй.(7.42)
- 5.2.9 Харилцаа холбооны сүлжээ, дамжуулж байгаа технологиос үл хамааран бүх төрлийн чат, мессеж (нийгмийн сүлжээгээр дамжиж байгаа зар сурталчилгаатай холбоотой мессеж мөн хамаарна), урсдаг зарыг телевизийн дэлгэц дээр гаргахгүй.(7.35)
- 5.2.10 Зар сурталчилгааны цагаас бусад цагт нэвтрүүлж буй нэвтрүүлгийн үеэр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний баннер хэлбэрийн зар сурталчилгаа, лого-г дэлгэц дээр гаргахгүй байна. Харин тухайн телевиз, сувгийн өөрийн хөтөлбөрийн талаарх мэдээлэл /нэкст/-ийг баннер хэлбэрийн зар сурталчилгаанд оруулж тооцохгүй. (7.36)
- 5.2.11 Гамшгийн болон онцгой байдлын нөхцөлд эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журмын дагуу шаардлагатай зар, мэдээллийг нийтэд үнэ төлбөргүй хүргэнэ. (7.47)
- 5.3 Теле-худалдааны сувгуудын тухайд:
- 5.3.1 Теле-худалдааны чиглэлээр төрөлжсөн телевизийн суваг нь энэхүү нөхцөл шаардлагын 3.1.12-д тодорхойлсон арилжаа, сурталчилгааны нэвтрүүлгээс бусад зар сурталчилгаа (реклам) явуулахгүй. (7.52.13)

- 5.3.2 Өөрийн теле-худалдааны сувгаар дамжуулан борлуулдаг бараа бүтээгдэхүүнээс бусад бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилсан, энэхүү нөхцөл шаардлагын 3.1.12-д тодорхойлсон арилжаа, сурталчилгааны нэвтрүүлгийн эзлэх хувь нь 06:00-24:00 цагийн хоорондох хөтөлбөрийн нийт цагийн 15%-иас хэтрэхгүй байна. (7.52.14)
- 5.3.3 Теле-худалдааны чиглэлээр төрөлжсөн сувгуудын 7 хоногийн хөтөлбөрт эзлэх, бараа бүтээгдэхүүний сурталчилгааны нийт цагийн 10%-иас доошгүй нь үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний сурталчилгаа байна. (7.52.15)
- 5.3.4 Өөрийн теле-худалдааны сувгаар дамжуулан худалдах боломжгүй, үндэсний жижиг дунд үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүнийг арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг хэлбэрээр сурталчилсан тохиолдолд Үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний хувь хэмжээнд оруулж тооцно. (7.52.16)
- 5.4 Өөрийн бүтээлийн хувь хэмжээг тооцоход:
- 5.4.1 Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 30% хувиас доошгүй нь өөрийн бүтээл байна. (7.15)
- 5.4.2 Монгол Улсын нутаг дэвсгэрт телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ хүргэхээр хамрах хүрээгээ өргөжүүлсэн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 35%-аас доошгүй нь өөрийн бүтээл байна. (5.1.11)
- 5.5 Төрөлжсөн чиглэлийн нэвтрүүлгийн хувь хэмжээг тооцоход:
- 5.5.1 Телевизийн сувгууд нь хөтөлбөрөө төрөлжсөн чиглэлээр бэлтгэн нэвтрүүлэх бөгөөд нэг хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 80 %-иас доошгүй нь төрөлжсөн чиглэлээр бэлтгэсэн агуулга байна. (7.52.1)
- 5.5.2 Хөтөлбөрт эзлэх төрөлжсөн чиглэлийн хувийг тооцохдоо 06:00-24:00 цагийн хоорондох хөтөлбөрийн нийт цагийг авч үзнэ. (7.52.2)
- 5.5.3 Төрөлжсөн чиглэлийн хувийг тооцохдоо тухайн төрөлжсөн нэвтрүүлгийн нийт цагт ногдох зар сурталчилгааны хугацааг оруулж тооцно. (7.52.3)
- 5.5.4 Танин мэдэхүйн төрөлжсөн сувгийн хөтөлбөрийн 60%-иас доошгүй нь төрөлжсөн чиглэлээрээ бэлтгэсэн агуулга байна. (7.52.4)
- 5.5.5 Танин мэдэхүйн төрөлжсөн суваг нь 18:00-23:00 цагийн хоорондох нийт эфирийн цагийн 80%-д зөвхөн төрөлжсөн чиглэлээр нэвтрүүлэг бэлтгэж хүргэнэ. (7.52.5)
- 5.5.6 Нийгэм эдийн засаг, Мэдээ мэдээллийн сувгийн хөтөлбөр нь зөвхөн төрөлжсөн чиглэлээр бэлтгэсэн агуулгатай байна. (7.52.6)
- 5.5.7 Зохицуулах хорооноос төрөлжсөн чиглэлүүдэд оруулж тооцох нэвтрүүлгийн талаар зөвлөмж гаргаж, хяналт мониторинг хийж төрөлжсөн чиглэлийн хувийг тооцохдоо ашиглана. (7.52.7)
- 5.6 Хүүхэд боловсрол, танин мэдэхүйн нэвтрүүлгийн хувь хэмжээг тооцоход:
- 5.6.1 Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн бэлтгэн дамжуулж байгаа соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх, хүүхэд боловсролын нэвтрүүлэг нь 1 сарын хөтөлбөрийн нийт цагийн 15%-аас багагүй байна. (7.16)



- 5.6.2 Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн бэлтгэн дамжуулж байгаа соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх, хүүхэд боловсролын нэвтрүүлэг нь 1 сарын хөтөлбөрийн нийт цагийн 20%-иас багагүй байна. (5.1.12)
- 5.7 Орон нутгийн бүтээлийн хувь хэмжээг тооцоход:
- 5.7.1 Монгол Улсын нутаг дэвсгэрт телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ хүргэхээр хамрах хүрээгээ өргөжүүлсэн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 5%-иас доошгүй нь бусад орон нутгийн мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг байна. (5.1.10)
- 5.7.2 Аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж байгаа телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрийн 30%-иас доошгүй нь тухайн орон нутагт хийгдсэн, тухайн орон нутгийн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч, студи продакшний бүтээл байна. (7.44)
- 5.8 Насны ангилал, стандартын хэрэгжилтийг тооцоход:
- 5.8.1 Нэвтрүүлгийн агуулгад насны ангилал тогтоож, түүнийг таних тэмдэг, тэмдэглэгээг стандартад заасны дагуу зурагтын дэлгэц дээр үзүүлнэ. Олон нийтэд нэвтрүүлгийн насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээг сурталчилж, таниулна. (7.21)
- 5.8.2 Бага, дунд насны хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, хүүхэлдэйн болон хүүхдийн киног орой 22:00 цагаас хойш нэвтрүүлэхгүй байна. (7.22)
- 5.8.3 Насанд хүрэгчдэд зориулсан насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээтэй буюу 18 наснаас дээш насныханд зориулсан кино, нэвтрүүлгийг өглөө 6:00-22:00 цагийн хооронд нэвтрүүлэхгүй, давтан дамжуулахгүй байна. (7.23)
- 5.9 Баннер, урсдаг зар, үгэн зар, тв тохиролцоо, тв худалдаа:
- 5.9.1 Харилцаа холбооны сүлжээ, дамжуулж байгаа технологиос үл хамааран бүх төрлийн чат, мессеж (нийгмийн сүлжээгээр дамжиж байгаа зар сурталчилгаатай холбоотой мессеж мөн хамаарна), урсдаг зарыг телевизийн дэлгэц дээр гаргахгүй. (7.35)
- 5.9.2 Зар сурталчилгааны цагаас бусад цагт нэвтрүүлж буй нэвтрүүлгийн үеэр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний баннер хэлбэрийн зар сурталчилгаа, лого-г дэлгэц дээр гаргахгүй байна. Харин тухайн телевиз, сувгийн өөрийн хөтөлбөрийн талаарх мэдээлэл /нэкст/-ийг баннер хэлбэрийн зар сурталчилгаанд оруулж тооцохгүй. (7.36)
- 5.9.3 Бизнес эрхлэгчид, иргэд, олон нийтийн байгууллагын мэдээлэл, сурталчилгааг зар сурталчилгааны (реклам) хэлбэрээр бус, фото, баннер, үгэн болон урсдаг зарын хэлбэрээр урьдчилан боловсруулж, хөтөлбөр хуваарьт оруулан, тусгайлан гаргасан зарын цагаар монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу алдаагүй, дуу оруулгатай нэвтрүүлж болно. (7.37)
- 5.9.4 Тухайн нэвтрүүлэгтэй эргэх холбоо тогтоох зорилгоор тухайн телевиз, сувгийн болон оролцогч байгууллага, хувь хүний утасны дугаарыг үзэгчдэд саад болохооргүй байдлаар тодорхой хугацаанд дэлгэц дээр байршуулж болох ба дэлгэц дээр байршуулахдаа “Өргөн нэвтрүүлгийн үгэн болон урсдаг мэдээллийн форматад тавих шаардлага” стандартыг мөрдөнө. (7.38)

- 5.9.5 Иргэдийн үзэл бодол, дуу хоолойг хүргэх зорилгоор нийгмийн сүлжээгээр дамжиж байгаа үзэл бодол, санал, шүүмжлэл мэдээллийг дэлгэц дээр харуулахад Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, энэхүү нөхцөл шаардлагыг хангасан, монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу бичиж, кирилл үсгээр сийрүүлсэн байна. (7.40)
- 5.9.6 Теле-худалдааны чиглэлээр төрөлжсөн телевизийн сувгаас бусад өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгаар бараа бүтээгдэхүүнийг студид байрлуулж сурталчлан борлуулсан тв тохиролцоо, тв худалдааны төрлийн нэвтрүүлэг дамжуулахгүй. (7.42)
- 5.9.7 “Урсдаг” болон “үгэн” хэлбэрийн мэдээ, мэдээллийг стандартын дагуу зөвхөн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг дундуур нэвтрүүлнэ. (7.43)

5.10 Тусгай дугаар, чат мессеж:

- 5.10.1 Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь нэвтрүүлэгтээ нэмүү өртөгтэй тусгай дугаар ашиглан үзэгч, сонсогчдыг оролцуулж байгаа тохиолдолд тухайн дуудлагын ярианы үнэ тарифыг ил тод, харагдахуйц байдлаар илэрхийлсэн байна. (7.14)
- 5.10.2 Харилцаа холбооны сүлжээ, дамжуулж байгаа технологиос үл хамааран бүх төрлийн чат, мессеж (нийгмийн сүлжээгээр дамжиж байгаа зар сурталчилгаатай холбоотой мессеж мөн хамаарна), урсдаг зарыг телевизийн дэлгэц дээр гаргахгүй. (7.35)
- 5.10.3 Мессежний тусгай дугаарыг тааварт тоглоом, кино сонгууль зэрэг уралдаант хэлбэрийн нэвтрүүлэгт ашиглахгүй байна. Мессежний тусгай дугаарыг зөвхөн санал асуулга, судалгаа авах зорилгоор ашиглаж болох бөгөөд тусгай дугаарын үнэ тарифыг ил тод мэдээлнэ. Энэ үед дэлгэц дээр урьдчилан заасан тоо, код, тэмдэгтийг гаргана. (7.41)

- 5.11 “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”, “Монгол улсын нутаг дэвсгэрт телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг хүргэхэд тавигдах нөхцөл шаардлага”-д заасан бусад үзүүлэлт.

Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу хяналт, мониторинг хийх үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2016 оны 29/17 дугаар тогтоолоор хамтран баталсан¹ “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-д заасан өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, сувгийн хөтөлбөрт тавигдах шаардлагыг баримтална.

6. ТАЙЛАН

- 6.1 “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”, “Монгол улсын нутаг дэвсгэрт телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг хүргэхэд тавигдах нөхцөл шаардлага”-ын дагуу сар бүр мониторингийн дүн ирүүлнэ. Сар, улирал, жилийн эцсийн байдлаар нэгдсэн дүн, мэдээ, аналитик тайланг форматын дагуу боловсруулж ирүүлнэ.

¹ СЕХ, ХХЗХ-ны 2017 оны 12/15 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан.

- 6.2 “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу хуулиар тогтоосон сонгуулийн сурталчилгааны хугацаанд мониторингийн дүн, тайлан мэдээг ирүүлнэ. Нэгдсэн дүн, аналитик тайланг форматын дагуу боловсруулж ирүүлнэ. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой тайлан, датаг Улаанбаатар хотын телевиз, сувгийн хувьд хөтөлбөр дамжуулсан өдрөөс хойш 2 хоногийн дотор, орон нутгийн телевиз, сувгийн хувьд бичлэг хөрвүүлснээс хойш 2 хоногийн дотор тус тус гаргаж захиалагчид нийлүүлнэ. Орон нутгийн телевиз, сувгийн хөтөлбөрийн бичлэгийг хөрвүүлэх хугацаа нь тухайн бичлэгийн формат, чанар, бичлэг хүлээн авах шийдлээс хамаарах тул урьдчилан тодорхойлох боломжгүй байна. Тайлан ирүүлэх хугацааны нарийвчилсан хуваарийг нэмэлтээр сонгуулийн сурталчилгааны хяналт эхлэхээс 1 сарын өмнө 2 тал тохиролцоно.
- 6.3 Хяналт, мониторинг хийгдсэн хугацааны эфирийн 06:00-01:00 цагийн /хөтөлбөрийн/ өдөр бүрийн дэлгэрэнгүй протокол, дэлгэрэнгүй протоколд тухайн нэвтрүүлэг эхэлсэн, дууссан, үргэлжилсэн хугацаа, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, тайлбар зэрэг бүх л мэдээллийг агуулсан байна;
- 6.4 Ажлын даалгаварын 4-р зүйлд заасан хяналт, мониторингийн үзүүлэлт тус бүрээр нэвтрүүлэг эхэлсэн дууссан үргэлжилсэн хугацааг цаг:мин:сек-р гаргах, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, нэмэлт тайлбар, хөтөлбөрт эзлэх хувь хэмжээ, 1 хоног, 7 хоног, сараар нэгтгэсэн дэлгэрэнгүй, хураангуй байдлаар шаталсан тайлан гаргах; */тайлангийн бүтэц, загварыг хавсралт 1-ээс харих/*
- 6.5 Хяналт, мониторингийн үзүүлэлт тус бүрээр шаталсан дэлгэрэнгүй, хураангуй тайлан гаргах;
- 6.6 Мониторингийн сар бүрийн дүнг үйлчилгээ эрхлэгч тус бүрээр мониторингийн дүн хүргүүлэх загварт оруулан програм хангамжийн тусламжтайгаар автоматжуулан гаргаж ирүүлнэ.
- 6.7 Мониторингийн сар бүрийн дүн, үзүүлэлтийг програмын тусламжтай форматын дагуу автоматаар инфографик, график, чарт хэлбэрт оруулан ирүүлнэ.
- 6.8 Үүссэн гомдол маргааныг шийдвэрлэх зорилгоор тухайн телевиз, сувгийн эфирийн бичлэгээс холбогдох нэвтрүүлгийн тодорхой цагийн бичлэг нийлүүлэх;
- 6.9 Тодорхой хугацаны дараа бичлэг устахаас өмнө Захиалагчид энэ талаар албажуулан албан тоотоор мэдэгдэж саналыг нь авсан байна.

7. АЖЛЫН ДААЛГАВРЫН ШАЛГУУР, ШААРДЛАГА

7.1 Ерөнхий шаардлага

- Зөвлөх болон хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд хамрагдаж байгаа этгээд нь компанийн тухай хуулийн 6.14-т заасан /нэг/ нэгдлийн оролцогчид биш байна.
- Зөвлөх нь хорооноос олгодог өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч бус байх, гүйцэтгэх удирдлагын хувьд сүүлийн 3 жил аль нэг өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх удирдлагаар ажиллагүй байна.

7.2 Техник хангамж, ажлын туршлага, хүний нөөцийн чадавхи, санхүүгийн хувьд тавигдах шалгуур

Энэхүү ажил нь өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгуудын тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт, мониторинг хийж, илэрсэн зөрчил дутагдлын дагуу шат дараатай арга хэмжээ авах үндэслэл шалтгаан болох бөгөөд шат дараатай арга хэмжээнд зөрчлийн талаар мэдэгдэх, сануулга өгөх, зөрчлийг арилгах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах, тусгай зөвшөөрлийг сунгах эсэх талаар дүгнэлт гаргах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ хамаарах тул хянуур нямбай ажиллаж, үнэн зөв алдаагүй тайлан гаргах, эфирийн дэлгэрэнгүй протокол, тайлан зөрүүгүй байх талаар анхаарч ажиллана. Энэхүү ажлын даалгаврыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд гэрээлэгч нь дараах нөөц боломж, чадвар, мэдлэг, туршлагыг хангах боломжтой байна. Үүнд:

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа жагсаалтад орсон өргөн нэвтрүүлгийн 20 телевиз, 62 суваг, МУ-д хамрах хүрээтэй орон нутгийн 5 телевиз, сонгуулийн сурталчилгааны үеэр нэмэлтээр орон нутгийн 64 телевиз, сувгийн хөтөлбөрт нэгэн зэрэг, байнгын хяналт, мониторинг хийх техникийн болон ажиллах хүчний чадавхийг бүрдүүлэх боломжтой байх. */жагсаалтыг хавсралт 2-оос харах/*
- Дээрх тооны телевиз, сувгуудын хөтөлбөрт байнгын хяналт, мониторинг хийх, эфирийн бичлэг хийх, хадгалах бүрэн хүчин чадал бүхий сервер, архивын техник төхөөрөмж, систем, шийдлийг бүрдүүлэх боломжтой байх.
- Хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд мониторингд хамрагдсан бүх телевиз, сувгийн эфирийн бичлэгийг 3 сар хадгалах серверийн тоног төхөөрөмж, шийдлийг бүрдүүлэх боломжтой байх.
- Жагсаалтад хамрагдсан өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн сигналыг хүлээн авах техникийн шийдэл, нөөц шийдэл, ОСДҮЭ-ээс сигнал хүлээн авч байгаа тохиолдолд аль болох олон ОСДҮЭ-ийн сигналыг хүлээн авах боломжтой байх.
- Цахилгааны доголдолоос хамааралгүйгээр хяналт, мониторинг хийх, эфирийг найдвартай тасралтгүй бичих, хэвийн ажиллагааг хангах нөөц станц зэрэг шийдлийг бүрдүүлэх боломжтой байх.
- Дата мэдээллийн сангаас шаардлагатай тохиолдолд холбогдох харьцуулалт, судалгаа, дүн, мэдээ, тайланг, эфирийн бичлэгийг тухайн сар, өдөр, цаг минутаар түргэн шуурхай гаргах техник, технологи, програм хангамжийн боломжийг бүрдүүлэх, хөгжүүлэх боломжтой байх.
- Хяналт, мониторингийн зөвлөх үйлчилгээг хийх аргачлал, хяналт, мониторингийн ажлын төлөвлөлт, ажил үүргийн хуваарийг гаргах, хяналт, мониторингийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах чадавхитай байх.
- Зөвлөхийн ирүүлэх санхүүгийн санал нь өртөгт суурилсан байх бөгөөд санхүүгийн саналын үндэслэл, тооцоог дэлгэрэнгүй байдлаар гаргаж тайлбартай ирүүлнэ. Мониторингийн ажлын төлөвлөлт, ажил үүргийн хуваарийн дагуу нэг ажилтанд ногдох эфирийн цаг, телевиз, сувгийн тоо, мониторингийн үзүүлэлт, тухайн ажилтны ажил үүрэгт Захиалагчийн ажлын эзлэх хувь, хэмжээ, ажлын ачаалал, зардлын тооцоо, төсвийг гаргаж үндэслэсэн байх.
- Нөхцөл шаардлагад өөрчлөлт орж хяналт, мониторинг хийх үзүүлэлт өөрчлөгдөх, нэмэлт оруулах тохиолдолд өөрчлөлтийг түргэн шуурхай хийх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой байх.

- Датабааз, файлын сан, програм хангамж, мэдээллийг цахим халдлагаас хамгаалах мэдээллийн аюулгүй байдлыг хангасан системийн шийдлийг бүрдүүлэх боломжтой байх.
- Урьдчилгаа төлбөр авалгүйгээр “Ажлын даалгавар”-т тусгасан ажлыг хэрэгжүүлэх санхүүгийн чадамжтай байх.

Зөвлөх нь хамгийн багадаа дараах хүснэгтэд тусгасан шаардлагатай мэдлэг чадвар, туршлагатай боловсон хүчнээс бүрдсэн баг санал болгох ба гэрээнд заасан ажил үүргийг заасан хугацаанд гүйцэтгэх чадвартай байна.

Албан тушаал	Чиг үүрэг	Ажлын туршлага
Багийн ахлагч	Ажлыг удирдан зохион байгуулах, гэрээлэгчийг төлөөлж захиалагчтай харилцах	<ul style="list-style-type: none"> • Судалгааны ажил, төсөл, багийн ажиллагаанд оролцож ажиллаж байсан туршлагатай байх • Судалгаа, шинжилгээ, статистик буюу холбогдох чиглэлээр зэрэг цолтой бол давуу тал болно
Хяналтын ажилтан	Хяналт, мониторингийн тайлан мэдээний бүтэц, загварыг боловсруулах, хяналт, мониторингийн явцад хяналт тавих	<ul style="list-style-type: none"> • Статистик , судалгаа шинжилгээний чиглэлээр ажиллаж байсан туршлагатай • Судалгаа шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах чадвартай • Мэдээ, тайланг алдаагүй, нягт нямбай гаргах чадвартай
Програм хангамж хариуцсан ажилтан	Програм хангамж боловсруулах, хөгжүүлэлт хийх	<ul style="list-style-type: none"> • Програм хангамжийн чиглэлээр ажилласан туршлагатай байх • Хяналт, мониторингийн ажлын талаар мэдлэг, туршлагатай байх • Програм хангамж боловсруулах, хөгжүүлэлт хийх чадвартай байх
Техник, ашиглалт хариуцсан ажилтан	Техникийн бүрэн бүтэн байдал, серверийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах	<ul style="list-style-type: none"> • Мэргэжлээрээ л ажилласан туршлагатай байх • Хяналт, мониторингийн ажлын талаар мэдлэг, туршлагатай байх • Техник төхөөрөмжийн шинэчлэлт хийх, ашиглалт үйлчилгээг хийх, техникийн өргөтгөл хийх чадвартай байх • Техникийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах чадвартай байх
Статистик судалгааны ажилтан	Хяналт, мониторингийн тайлан мэдээнд анализ, шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> • Статистик , судалгаа шинжилгээний чиглэлээр боловсрол эзэмшсэн • Дээд боловсролтой • Судалгаа шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах чадвартай байх
Мониторингийн ажилтан	Бүртгэл хийх, тайлан бэлдэх	<ul style="list-style-type: none"> • Их хэмжээний мэдээллийн баазтай ажиллах чадвартай

8. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ БА АЖЛЫН ХУВААРЬ

Зөвлөх нь энэхүү ажлын даалгаврын хүрээнд хөтөлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах арга зүй, үйл ажиллагааны хуваарийг болосруулна. Энэхүү үйл ажиллагааны хуваарьт төлөвлөгөө болон үүнтэй ижил төстэй даалгаврыг ямар хугацаа, техникийн туслалцаа, ажлын бүтэц бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэж байсан туршлагын баримтжуулалтыг хавсаргавал зохино.

9. ТАЙЛАН ИРҮҮЛЭХ УДИРДАМЖ

Хяналт, мониторингийн тайлан мэдээг долоо хоног, сараар нэгтгэн гаргаж захиалагч талд электрон хэлбэрээр сар бүрийн тодорхой хугацаанд хүлээлгэн өгнө. Тайлан ирүүлэхдээ тайлангийн хугацаанд хамрагдсан телевиз, сувгуудын тоо, үүнд шинээр нэмэгдсэн эсвэл хяналт, мониторингид хамрагдаагүй бол хамрагдаагүй шалтгаан зэргийг тайлбарласан товч тайлбар, тайлан, нотломжийг хамт ирүүлнэ. Захиалагч тал зөвлөхтэй байгуулах гэрээнд тайлангийн төрөл, тайлангийн төрлүүдийг ямар хугацаагаар авах тухайгаа тодорхой тусгана.

Зөвлөх нь тайлангийн бүтэц, аргачлалын дагуу тайланг нэгтгэж, дүгнэлт гаргахад ойлгомжтой, ирүүлсэн тайлан, мэдээг шууд ашиглах боломжтой, дахин боловсруулалт хийх шаардлагагүй, хялбар байдлаар ирүүлнэ.

9.1 Тайлан гаргах хугацааны хуваарь, хүргүүлэх хэлбэр

- Тухайн сарын хяналт, мониторингийн тайлан, датаг дараа сарын 10-ны дотор, электрон хэлбэрээр гаргаж захиалагчид нийлүүлнэ. Тайлан ирүүлэх хугацааг гэрээ байгуулахад нарийвчлан 2 тал тохиролцож шийдвэрлэнэ.
- Мониторингийн дүнгийн дагуу улирал, жилээр гаргах аналитик тайланг улирлын хувьд дараа улирлын эхний сарын 30-ны дотор, жилийн хувьд дараа жилийн эхний улиралд багтаан ирүүлнэ.
- Мониторингийн дүнгээр хүргүүлэх албан тоот, инфографик, график, чарт хэлбэрийн тайланг сар бүр ирүүлэх тайлангийн хамт дараа сарын 10-ны дотор, электрон хэлбэрээр гаргаж ирүүлнэ.
- Сонгуулийн сурталчилгаатай холбоотой тайлан, датаг Улаанбаатар хотын телевиз, сувгийн хувьд хөтөлбөр дамжуулсан өдрөөс хойш 2 хоногийн дотор, орон нутгийн телевиз, сувгийн хувьд бичлэг хөрвүүлснээс хойш 2 хоногийн дотор тус тус гаргаж захиалагчид нийлүүлнэ. Орон нутгийн телевиз, сувгийн хөтөлбөрийн бичлэгийг хөрвүүлэх хугацаа нь тухайн бичлэгийн формат, чанар, бичлэг хүлээн авах шийдлээс хамаарах тул урьдчилан тодорхойлох боломжгүй байна. Тайлан ирүүлэх хугацааны нарийвчилсан хуваарийг нэмэлтээр сонгуулийн сурталчилгааны хяналт эхлэхээс 1 сарын өмнө 2 тал тохиролцоно.
- Тухайн сарын хяналт, мониторингийн тайланг өгөхдөө тухайн сарын товч тайлан (ажлын даалгаварын 4-р зүйлд заасан хяналт, мониторингийн үзүүлэлтийн дагуу гаргасан тайлан телевиз, суваг тус бүрийн нэгдсэн дүн мэдээ тайлан, тайлангийн хугацаа зэргийг агуулсан байна), хяналт, мониторингд хамрагдсан хугацаа, хамрагдсан телевиз, сувгуудын жагсаалт, хяналт, мониторингд хамрагдаагүй газруудын жагсаалт, тайлбар (хамрагдаагүй шалтгаан, тайлбарын хамтаар) зэргийг тусгаж нотломж үйлдэн ирүүлнэ.
- Гүйцэтгэгчийн хяналтын ажилтан өдөр бүрийн тайланг нэгтгэн дараа сарын эхэнд программын аргаар датабазаас Excel хэлбэрээр тайлангуудыг гаргаж, Захиалагчид и-мэйлээр илгээнэ. Тайлан бүрийг дэлгэрэнгүй болон хураангуй 2 хэлбэрээр гаргах ба нийт тайланг CD-д бичиж баталгаажуулан захиалагчид нэхэмжлэхийн хамт биечлэн хүргүүлнэ.

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ /загвар/

- 1.1 Эфирийн тухайн 7 хоногийн өдөр бүрийн (06:00-01:00) протокол; Эфирийн өдрийн протокол нь огноо, тухайн нэвтрүүлэг эсвэл зар сурталчилгаа эхэлсэн, дууссан хугацаа, үргэлжилсэн хугацаа, нэр, төрөл зэрэг бүх л мэдээллийг агуулсан байна. (Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн хувьд өдрийн эфирийн бичлэгийг 06:00-01:00 хүртэл, сувгуудын хувьд 06:00-24:00 хооронд байх).
- 1.2 Телевиз, сувгуудын арилжааны зар сурталчилгааны цацалтын хугацааг үндсэн эфирийн цаг тус бүрээр нь тусад нь гаргасан өдөр бүрийн тайлан, болон хураангуй тайлан; уг тайлан нь эфирийн аль цагт, ямар нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгааны хэтрэлт гарсан, зар сурталчилгааны төрөл, тайлбар, хэтрэлтийн нэгдсэн дүнгагуулсан байна. Зар сурталчилгааны хэтрэлтийг тайлан хүснэгтийн дор 7 хоног, сараар нэгтгэж нийц цагийг гаргана.
- 1.3 Телевиз, сувгуудын хөтөлбөрт Үндэсний бүтээлийн хувь хэмжээг гаргасан тайланд нэвтрүүлэг эхэлсэн дууссан хугацаа, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, дотоод, гадаад болох тайлбар, 7 хоногийн эцэст хөтөлбөрийн нийт цагийг **цаг:мин: сек-р** гаргах, үндэсний бүтээлийн нийт цаг, эзлэх хувийг агуулсан байна. Үндэсний бүтээл, гадаад нэвтрүүлгийн талаарх тайлан гаргахдаа гадаад хэл дээрх нэвтрүүлгийг дуу оруулаагүй, хадмал орчуулгагүй гаргасан бол тухайн нэвтрүүлгийн үргэлжилсэн хугацааг тэмдэглэж 7 хоног, сараар дүнг нэгтгэнэ.
- 1.4 Өргөн нэвтрүүлгийн телевизийн хөтөлбөрт эзлэх соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх чиглэлийн нэвтрүүлгийн нийт хугацаа, эзлэх хувийг өдөр бүрээр гаргасан тайлан; уг тайлан нь огноо, тухайн нэвтрүүлэг эхэлсэн, дууссан, үргэлжилсэн хугацаа, нэр, төрөл, хоногийн нийт нэвтрүүлгийн үргэлжилсэн хугацаа зэргийг тухайн хоногт:
 1. Хүүхэд хүмүүжил боловсролын,
 2. Үндэсний хэл соёл, зан заншил, түүх, уламжлалын,
 3. Эрүүл мэнд байгаль экологи
 4. Шинжлэх ухаан танин мэдэхүйн нэвтрүүлгээр нь ангилж харуулна.Эдгээр тайланг долоо долоо хоногоор нэгтгэсэн тайланг хураангуй байдлаар мөн гаргана.
- 1.5 Сувгуудын төрөлжсөн чиглэлийн нэвтрүүлгийн эзлэх хувь хэмжээг төрөлжсөн чиглэлд оруулж тооцсон нэвтрүүлгүүдийг тодруулж, нэмэлт тайлбар эсхүл өнгөөр ялгасан байдлаар харуулсан тайлан.
- 1.6 Теле-худалдааны чиглэлээр төрөлжсөн сувгуудын тайланг тусад нь гаргаж, ажлын даалгаварт өгсөн үзүүлэлтийн дагуу хийсэн мониторингийн дүнг 7 хоног, сараар нэгтгэж гаргана.
- 1.7 Насанд хүрэгчдэд зориулсан насны ангиллын тэмдэг тэмдэглэгээтэй буюу 18 наснаас дээш насныханд зориулсан кино, нэвтрүүлгийг 06:-22:00-ийн хооронд нэвтрүүлсэн, давтан дамжуулсан зөрчил гаргасан телевиз, сувгуудын зөрчлийн тайланг 7 хоног, сараар нэгтгэж гаргах, дамжуулсан огноо, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, тайлбарын хамт гаргана гэх мэт байна.

ТЕЛЕВИЗ, СУВГИЙН ЖАГСААЛТ /2020.01.13-ны байдлаар/

Улаанбаатар хотын телевиз, суваг

Д/Д	ЭЗЭМШИГЧ	ЗӨВШӨӨРӨЛ	АНГИЛАЛ	ДУУСАХ	ТЕЛЕВИЗИЙН НЭР	ХАМРАХ ХҮРЭЭ
1	АЭ энд ЖААГ ХХК	13000005	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2022-05-06	25-р суваг	Монгол Улс
2	Улаанбаатар телевиз ХХК	13000006	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2024-01-01	UBS Телевиз	Монгол Улс
3	Гэгээн далай ХХК	13000011	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2022-06-06	ТВ 5 телевиз	Монгол Улс
4	Алсын гэрэл ХХК	13000018	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2024-01-01	ТМ телевиз	Монгол Улс
5	Супер вижн медиа групп ХХК	13000019	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2022-08-17	SBN телевиз	Монгол Улс
6	Суваг ти ви найм ХХК	13000024	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2023-04-11	TV 8 телевиз	Монгол Улс
7	Эм Би Эс ХХК	13000025	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2023-04-13	С1 телевиз	Монгол Улс
8	Медиа холдинг ХХК	13000026	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2023-01-31	ТВ9 телевиз	Монгол Улс
9	Тэнгэрлэг эх орон ХХК	13000028	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2023-07-01	Эх орон телевиз	Монгол Улс
10	Эп Ти Ви Бродкастинг ХХК	13000029	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2023-07-04	NTV	Монгол Улс
11	Ийгл Бродкастинг ХХК	13000031	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2023-10-12	Ийгл ньюс	Монгол Улс
12	Монгол телевиз ХХК	13000049	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2022-12-15	Монгол ТВ	Монгол Улс
13	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК	13000093	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2023-04-01	Стар телевиз	Монгол Улс
14	Про медиа нетворк ХХК	13000092	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2023-01-31	Ви Ти Ви телевиз /VTV television/	Монгол Улс
15	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	13000110	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2024-06-27	MNB - 1	Монгол Улс
16	Имерж медиа ХХК	13000122	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2022-11-01	ETV телевиз	Монгол Улс
17	Медиа боловсрол суваг ХХК	13000139	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2023-01-31	Боловсрол суваг телевиз	Монгол Улс
18	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	13000142	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2023-05-20	MNB - 2	Монгол Улс
19	Улс сүлд ХХК	13000159	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2024-01-30	Сүлд телевиз	Монгол Улс
20	Хүннү ХХК	13000158	Телевизийн өргөн нэвтрүүлэг	2024-01-30	Малчин телевиз	Монгол Улс

Л/Л	ЭЗЭМШИГЧ	ЗӨВШӨӨРӨЛ	АНГИЛАЛ	ДУУСАХ	СУВГИЙН НЭР /ЧИГЛЭЛ/	ХАМРАХ ХҮРЭЭ
1	Парламентын суваг ХХК	12900003	Кабелийн суваг	2020-04-26	Парламентийн суваг /Мэдээ, мэдээлэл/	Улаанбаатар хот
2	Медиа холдинг ХХК	12900007	Кабелийн суваг	2022-04-26	TV9-2 /Кино/	Монгол Улс
3	Эх гоёот медиа ХХК	12900004	Кабелийн суваг	2020-04-26	Channel11 Entertainment /Цэнгээнт/	Монгол Улс
4	Мөрөөдлийн суваг ТББ	12900001	Кабелийн суваг	2020-04-26	DREAMBOX /Хүүхэд, боловсрол/	Монгол Улс

5	Шууд Ти Ви ХХК	12900002	Кабелийн суваг	2020-04-26	Лайв телевиз /Теле-Худалдаа/	Монгол Улс
6	Эм Ви Эс ХХК	12900012	Кабелийн суваг	2020-05-06	Mon Plus /Цэнгээнт/	Улаанбаатар хот
7	Мөүвибокс ХХК	12900017	Кабелийн суваг	2020-05-06	Movie box /Кино/	Монгол Улс
8	Эйшн бокс ХХК	12900013	Кабелийн суваг	2020-05-06	Asian box /Кино/	Монгол Улс
9	Өлзий медиа ХХК	12900009	Кабелийн суваг	2020-05-06	Өлзий телевиз /Нийгэм, эдийн засаг/	Монгол Улс
10	Форчун глобал ХХК	12900018	Кабелийн суваг	2020-05-06	Глобал ТВ /Теле худалдаа/	Монгол Улс
11	Гэгээн далай ХХК	12900014	Кабелийн суваг	2020-05-06	ТВ5-2 /Теле-худалдаа/	Монгол Улс
12	Эвергрийнлайф ХХК	12900022	Кабелийн суваг	2020-05-31	7-р суваг /Цэнгээнт/	Монгол Улс
13	Эн Би Жи Кинг Монголиа ХХК	12900021	Кабелийн суваг	2020-05-31	Royal /Нийгэм, эдийн засаг/	Монгол Улс
14	Хатрек ХХК	12900029	Кабелийн суваг	2020-06-27	Eco Channel /Байгаль, экологи/	Монгол Улс
15	Эс Си Эйч ХХК	12900027	Кабелийн суваг	2020-06-27	Суваг 1 /Танин мэдэхүй/	Монгол Улс
16	Ти Ви Арав ХХК	12900033	Кабелийн суваг	2020-11-01	TV10 /Нийгэм, эдийн засаг/	Монгол Улс
17	Ханлиг Өлзий ХХК	12900037	Кабелийн суваг	2021-12-06	Тэнгэр /Кино/	Улаанбаатар хот
18	Нэйшнл ньюс корпорэйшн ХХК	12900040	Кабелийн суваг	2020-12-06	Блүүмберг суваг /Нийгэм, эдийн засаг/	Монгол Улс
19	Модерн Кастрл Модифаер ХХК	12900039	Кабелийн суваг	2020-12-06	Соён гэгээрүүлэгч /Шинжлэх ухаан, танин мэдэхүй/	Монгол Улс
20	Монголиан ньюс чаннел ХХК	12900048	Кабелийн суваг	2021-12-30	MNC /Мэдээ, мэдээлэл/	Монгол Улс
21	Ди Ви Продакшн ХХК	12900042	Кабелийн суваг	2021-12-30	TV3 /Танин мэдэхүй/	Монгол Улс
22	Гэгээн далай ХХК	12900061	Кабелийн суваг	2022-02-13	Moviemax /Кино/	Монгол Улс
23	Випмедиа групп ХХК	12900066	Кабелийн суваг	2022-05-10	MNBA /Спорт/	Монгол Улс
24	Волюм плас ХХК	12900085	Кабелийн суваг	2022-05-10	Volume Plus /Цэнгээнт/	Монгол Улс
25	Реал Мастер Линкс ХХК	12900076	Кабелийн суваг	2022-05-10	Like суваг /Эрүүл мэнд/	Монгол Улс
26	Дөрөв кэй ХХК	12900072	Кабелийн суваг	2022-05-10	4K SMART /Танин мэдэхүй/	Монгол Улс
27	Монгол масс медиа ХХК	12900067	Кабелийн суваг	2022-05-10	Documentary Box /Баримтат кино/	Монгол Улс
28	Дэлхийн чимээ медиа групп ХХК	12900068	Кабелийн суваг	2022-05-10	WORLD /Нийгэм, эдийн засаг/	Монгол Улс
29	Трейд телевиз ХХК	12900091	Кабелийн суваг	2022-05-25	Трейд суваг /Теле-худалдаа /	Монгол Улс
30	Би Энд Би Пикчерс ХХК	12900094	Кабелийн суваг	2020-05-31	Оллоо /Танин мэдэхүй/	Монгол Улс
31	Малчин телевиз ХХК	12900096	Кабелийн суваг	2021-12-27	Мянгат Malchin /Мэдээ, мэдээлэл/	Монгол Улс
32	Дөрөв кэй мүүв ХХК	12900097	Кабелийн суваг	2021-12-30	Талын Монгол /Танин мэдэхүй/	Монгол Улс
33	Эн Ти Эн Эйч Ди Медиа Групп ХХК	12900098	Кабелийн суваг	2022-03-23	NTN /Шинжлэх ухаан, танин мэдэхүй/	Монгол Улс

34	Эс Пи Эс Эйч Ди ХХК	12900102	Кабелийн суваг	2022-09-20	SPS National /Спорт/	Монгол Улс
35	Мюзик бокс ХХК	12900105	Кабелийн суваг	2022-09-20	E-box /Хөгжим/	Монгол Улс
36	Масс Ти Ви ХХК	12900107	Кабелийн суваг	2022-10-25	Масс ТВ /Нийгэм эдийн засаг/	Монгол Улс
37	Эгон ХХК	12900106	Кабелийн суваг	2020-05-06	ШОП Монголия /Теле-худалдаа/	Монгол Улс
38	Монзах ХХК	12900123	Кабелийн суваг	2020-04-26	NTV+ /Энтертайнмент/	Монгол Улс
39	Оргил медиа консалтинг ХХК	12900127	Кабелийн суваг	2020-04-26	O TV /Цэнгээнт/	Монгол Улс
40	Эс Пи Эс Эйч Ди ХХК	12900131	Кабелийн суваг	2022-04-22	SPS Fight /Спорт/	Монгол Улс
41	Эс Пи Эс Эйч Ди ХХК	12900134	Кабелийн суваг	2022-04-22	SPS Prime /Спорт/	Монгол Улс
42	Эс Пи Эс Эйч Ди ХХК	12900133	Кабелийн суваг	2022-04-22	SPS Classic /Спорт/	Монгол Улс
43	Эс Пи Эс Эйч Ди ХХК	12900132	Кабелийн суваг	2022-04-22	SPS World /Спорт/	Монгол Улс
44	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	12900136	Кабелийн суваг	2022-05-13	MNB -3 /Спорт/	Улаанбаатар хот
45	Сарны чулуу анар ХХК	12900324	Кабелийн суваг	2020-05-31	TV6 /Байгаль экологи/	Улаанбаатар хот
46	Маст технологи ХХК	12900325	Кабелийн суваг	2020-08-30	news channel /Мэдээ, мэдээлэл/	Улаанбаатар хот
47	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	12900328	Кабелийн суваг	2020-12-27	MNB - 4 /Танин мэдэхүй/	Улаанбаатар хот
48	Буган соёл ХХК	12900330	Кабелийн суваг	2021-02-22	Хөх Монгол /Танин мэдэхүй/	Улаанбаатар хот
49	Энтертайнмент интэрпрайс ХХК	12900331	Кабелийн суваг	2021-04-27	Бидний цөөхөн Монголчууд /Танин мэдэхүй/	Монгол Улс
50	Натурхаан медиа ХХК	12900332	Кабелийн суваг	2021-05-30	ТВ1 /Мэдээ мэдээлэл/	Улаанбаатар хот
51	Найс ти ви ХХК	12900333	Кабелийн суваг	2021-07-19	АВТО /Шинжлэх ухаан, танин мэдэхүй/	Улаанбаатар хот
52	Эс Пи Эс Эйч Ди ХХК	12900334	Кабелийн суваг	2021-07-19	SPS Unique //	Улаанбаатар хот
53	Си чаннель ХХК	12900335	Кабелийн суваг	2021-08-31	Си чаннель //	Улаанбаатар хот
54	Одод ти ви суваг ХХК	12900336	Кабелийн суваг	2021-12-31	Одод /Спорт/	Улаанбаатар хот
55	Монвсат нэтворк ХХК	12900338	Кабелийн суваг	2022-02-27	Mongolsat Кино /Кино/	Улаанбаатар хот
56	Хүннү ХХК	12900337	Кабелийн суваг	2022-02-27	Малчин-Бирж /Танин мэдэхүй/	Монгол Улс
57	Орчил ивэг ХХК	12900339	Кабелийн суваг	2022-07-03	Орчил UHD телевиз //	Улаанбаатар хот
58	Хаппи веритас ХХК	12900340	Кабелийн суваг	2022-08-19	GTV /Эрүүл мэнд/	Улаанбаатар хот
59	Хит-Интертаймент ХХК	12900341	Кабелийн суваг	2022-09-18	НIT /Цэнгээнт/	Улаанбаатар хот
60	Эм Эн Медиа Групп ХХК	12900342	Кабелийн суваг	2022-09-18	//	Улаанбаатар хот
61	Юпланэт ХХК	12900343	Кабелийн суваг	2022-11-25	//	Монгол Улс
62	Эм Ди Энтертаймент ХХК	12900344	Кабелийн суваг	2022-12-18	TV 2 /Цэнгээнт/	Монгол Улс

Орон нутгийн телевиз, суваг

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Үйлчилгээний нэр	Хамрах хүрээ	Тусгай зөвшөөрлийн дугаар
Архангай аймаг				
1	Мичид Ньус ХХК	Тамир ТВ	Эрдэнэбулган сум	13000138
2	Ар Би Эм Ти ХХК	АВ ТВ	Эрдэнэбулган сум	13000121
Баянхонгор аймаг				
3	МТД ХХК	Хонгор ТВ	Баянхонгор сум	13000048
4	Өлзийтийн хийморь өөдөө ХХК	Баянхонгор ТВ	Баянхонгор сум	13000062
5	Хөгжлийн ертөнц телевиз ХХК	Мазаалай ТВ	Баянхонгор сум	13000164
Говь-Алтай аймаг				
6	Ханлиг тайшир ХХК	Миний нутаг ТВ	Есөнбулаг сум	13000045
Говь-Сүмбэр				
7	Теч смарт солошн ХХК	Залуусын ТВ	Сүмбэр, Шивээговь, Баянтал сумд	13000152
Дархан - Уул аймаг				
8	Дархан мэдээлэл төв ХХК	DBS TV	Дархан-Уул аймаг Дархан сум	13000032
9	ТВ дөрөв ХХК	TV4	Монгол Улс	13000004
10	Ай Жи Би Ти Виз ХХК	RGB TV	Дархан сум	13000033
11	Иргэн М. Мөнхбаяр	Од ТВ	Шарын гол сум	13000104
Дорноговь аймаг				
12	Ж. Ганчимэг	Замын үүд ТВ	Замын Үүд сум	13000135
Дорнод аймаг				
13	Ашдын нөхөр ХХК	Дорнод ТВ	Хэрлэн сум	13000100
14	Гэгээн гэгээ ХХК	Мижи ТВ	Хэрлэн сум	13000102
15	Шинэ зураг ХХК	Нутаг 21	Дорнод аймаг Хэрлэн сум	13000039
16	Дорнын Хэрлэн тал НҮТББ	Дорнын ТВ6	Дорнод аймаг Хэрлэн сум	13000151
Дундговь аймаг				
17	Буянт чандмань социал медиа ХХК	Маргад ТВ	Дундговь аймаг Сайнцагаан сум	13000084
Завхан аймаг				
18	Д. Батдорж	AIR1 ТВ	Улиастай сум	13000041
19	Жавхлант ширээт ХХК	Завхан ТВ	Улиастай сум	13000106

Орхон аймаг				
20	Монгол Оросын хамтарсан ЭРДЭНЭТ үйлдвэрТӨҮГ	Эрдэнэт ТВ	Баян-Өндөр сум	13000088
21	Фило ХХК	TV24	Монгол Улс	13000023
22	Номин Макс ХХК	New broadcasting Television	Баян-Өндөр сум	13000022
23	Ситиблессинг ХХК	MBS TV	Баян-Өндөр сум	13000103
24	Ишилан ХХК	EBS TV	Баян-Өндөр сум	13000112
25	Эрдэнэт таймс сонин ХМХ	etv	Баян-Өндөр сум	13000081
26	Очир роуд ХХК	Тусгал 1 ТВ	Баян-Өндөр сум	13000083
27	Асгатын гол ХХК	Мэдээллийн бирж	Баян-Өндөр сум	13000096
28	Бунадо ХХК	Тэнгэр ТВ	Баян-Өндөр сум	13000133
Өвөрхангай аймаг				
29	Төгөлдөр өв ХХК	Арвайхээр чөлөөт суваг	Арвайхээр сум	13000126
30	Дөлгөөн соёмбо ХХК	Соёмбо ТВ	Арвайхээр сум	13000118
31	Хас-Өрлөг ТББ	Хас ТВ	Арвайхээр сум	13000107
32	Гэгээн соёмбо ХХК	GMN ТВ	Арвайхээр сум	13000162
33	Буган соёл ХХК	Их Монгол	Хархорин сум	13000157
Өмнөговь аймаг				
34	Түвдэнгийн Бор Интернэшнл ХХК	Алтан говь ТВ	Даланзадгад сум	13000014
35	Ёл цуурай ХХК	(UC TV) Өмнөговийн төв телевиз	Даланзадгад сум	13000035
36	Говийн долгион мэдээллийн төв НҮТББ	Ариг бүрд ТВ	Даланзадгад сум	13000070
Сүхбаатар аймаг				
37	Дагуком ХХК	BBS TV	Монгол улс	13000027
38	Морьтын ширээ ХХК	SB TV	Монгол улс	13000116
Сэлэнгэ				
39	Миний Монгол Энтертайнмэнт ХХК	Миний монгол	Сүхбаатар сум	13000047
40	Хэрх-Өргөө ХХК	Таны Сэлэнгэ ТВ	Сүхбаатар сум	13000089
41	МДЛО ХХК	Мандал ТВ	Мандал сум	13000078
42	Мөнхгавшгай ХХК	Эрдэнэ ТВ	Сайхан сум	13000130
Төв аймаг				
43	Төв ньюс ХХК	TBS	Зуун мод сум	13000141
44	Очир Арвай ХХК	Төв ТВ	Зуун мод сум	13000150
Увс аймаг				

45	Сама Увс ХХК	Увс ТВ	Улаангом сум	13000017
46	Хоса ТВ ХХК	МВС ТВ	Увс аймагт	13000060
47	Хийморлог эрчүүдийн хүч ХХК	Увс төв ТВ	Улаангом сум	13000147
Ховд аймаг				
48	Огторгуйн асар нийтийн мэдээллийн төв НҮТББ	Ховд телевиз	Жаргалант сум	13000003
49	Эко Жаргалант ХХК	Эко ТВ	Жаргалант сум	13000095
50	Некст дэвшил ХХК	Олон ястны телевиз	Жаргалант сум	13000149
51	Хувь хүний хөгжил баруун бүсийн институт НҮТББ			
Хөвсгөл аймаг				
52	Хөвсгөл мэдээллийн төв НҮТББ	Далай ээж ТВ	Мөрөн сум	13000002
53	Үзэсгэлэнт мөрөн ХХК	Мөрөн Тв	Мөрөн сум	13000085
54	Өсөх прогресс ХХК	Хөвсгөл ТВ	Мөрөн сум	13000134
Хэнтий аймаг				
55	Өндөрхаан цахим ертөнц ТББ	Өндөрхаан ТВ	Хэрлэн сум	13000144
56	Эрчит хурдан хүлэг ХХК	Бүргэд ТВ	Хэрлэн сум	13400117
Багануур				
57	Иргэн Ц.Адъяа	Сүлжээ ТВ	УБ хот Багануур дүүрэг	13000163
Налайх				
58	Буян налайх ХХК	Буян телевиз	Налайх дүүрэг	13000007

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Үйлчилгээний нэр	Төрөлжсөн чиглэл	Хамрах хүрээ	Тусгай зөвшөөрлийн дугаар
Баян-Өлгий аймаг					
1	Дербес ХХК	Дербес ТВ	/Мэдээ, мэдээлэл/	Өлгий сум	12900113
2	Эм Юу Ти Эй ХХК	Саян ТВ	/Мэдээ мэдээлэл/	Баян-Өлгий аймагт	12000129

3	Омирагаш крафт ХХК	TV-4	/Мэдээ, мэдээлэл/	Өлгий сум	12900117
Булган аймаг					
4	Сайхан Монгол ЭИАК ТББ	Сайхан Монгол ТВ	Нийгэм эдийн засаг	Булган сум	12900329
Дорноговь аймаг					
5	Наран аялгуу ХХК	DSB	Нийгэм эдийн засаг	Монгол улс	12900130
6	Ди медиа агентлаг	DTV	Цэнгээнт	Сайншанд сум	12900319
Дорнод аймаг					
7	Ийст юу би өү ХХК	D1	Цэнгээнт	Хэрлэн сум	12900135
Хөвсгөл					
8	Иргэн П.Жаргал	Түмний ТВ	Нийгэм, эдийн засаг	Мөрөн сум	12900322
Ховд аймаг					
9	Эхлэх шинэ жаргалант ХХК	Жаргалант ТВ	Нийгэм, эдийн засаг	Ховд аймагт	12900128

---00000---